



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 80

Онги

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Ашигт малтмал, газрын тосны газраас тус сумын нутаг дэвсгэр Онги багийн нутаг “Ахар уул”-ын агнуурын бүс нутагт 2325,33 га, Мааньт багийн нутаг “Сагарт”, “Шар тойрмын хөндий” орчмын 2679,93 га нийт 5005,26 га талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох санал ирүүлснийг сумын иргэдийн төлөөлөгчдийн 100 хувийн буюу олонхын саналаар дээрх асуудлыг дэмжээгүйд тооцсугай. Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаар хэлэлцээд хуралд оролцсон

Хоёр. Тус Ашигт малтмалын газраас ялгаж ирүүлсэн талбайд орж буй “Ахар” уул орчмын бүс нутгийг сумын ИТХ-ын 2015 оны 35 дугаар тогтоолоор Агнуурын бүс нутаг болгон тогтоосон, “Сагарт”, “Шар тойрмын хөндий” орчмын нутаг нь сумын адууны өвлийн отрын бүс нутаг тул ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжгүй гэж үзсүгэй.

Гурав. Хуралдаанаас гарсан шийдвэрийг “Ашигт малтмалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн хугацаанд багтааж дээд шатны Засаг даргад хүргүүлж ажиллахыг сумын Засаг дарга (С.Амарсанаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ц.АДЪЯА-ОТГОН